



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар A/89

Жаргалтхаан сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дугаар зүйлийн 59.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/207 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/436 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад сумын нийт бог малын төлийг хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 30-аас эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.

3.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

4.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай тарилгыг татан авч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын дүнг нэгтгэн танилцуулж, тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч П.Батдуламд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГАНБАТ

